



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 7 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 304

Улаанбаатар
хот

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай

Төмөр замын тээврийн тухай хуулийн 6.2, 9.1.1, 23.1, Барилгын тухай хуулийн 32.1.5, Улсын Их Хурлын 2018 оны 73 дугаар тогтоолын 1 дэх заалтын 2, 3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 8-ны өдрийн 242 дугаар тогтоолоор байгуулагдсан “Тавантолгой төмөр зам” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцааны 66 хувийг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-д, 34 хувийг “Монголын төмөр зам” ТӨХК-д тус тус эзэмшүүлэх, холбогдох журмын дагуу бүртгүүлэх арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (А.Ариунболд)-т тус тус даалгасугай.

2. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барьж байгуулах, ашиглахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг техник, эдийн засгийн үндэслэлд заасан дүнгээр нүүрс урьдчилан борлуулах замаар болон бусад эх үүсвэрээр санхүүжүүлэх арга хэмжээ авахыг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (М.Баяраа)-д зөвшөөрч, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (А.Ариунболд)-т даалгасугай.


3. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийн барилгын ажлын зөвшөөрлийг “Тавантолгой төмөр зам” ХХК-д олгосугай.

4. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийн барилгын ажлыг 2019 оны 8 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн үргэлжлүүлж, 2021 онд ашиглалтад оруулах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт үүрэг болгосугай.

5. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтэц, түүний технологийн иж бүрдэл болох инженерийн байгууламж, эрчим хүч, усан хангамж, өртөө, зөрлөгийн болон дохиолол холбоо, мэдээллийн барилга байгууламжийг барихад шаардлагатай холбогдох зөвшөөрөл, техникийн нөхцөлийг зохих журмын дагуу тухай бүр шуурхай олгохыг Өмнөговь аймгийн Засаг дарга Н.Наранбаатарт үүрэг болгосугай.

6. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, ажлын явц, үр дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулж байхыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгасугай.

7. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг эрчимжүүлэх тухай” Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 8-ны өдрийн 242 дугаар тогтоолын 4, 5 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Зам, тээврийн хөгжлийн сайд

У.ХҮРЭЛСҮХ

Б.ЭНХ-АМГАЛАН